

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 09 дүгээр сарын 15

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит XV хуралдаанаар хэлэлцэх асуудлуудын бэлтгэлийг сайтар хангаж, нийт байгууллагын удирдлагууд хуралд идэвхтэй оролцох, бүртгэлд хяналт тавих. /Нийт байгууллагуудын удирдлагууд/				
1.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн XV хуралдаанд Чингэлтэй дүүргээс сонгогдсон НИТХ-н төлөөлөгч, Засаг дарга Н. Батсүмбэрэл, Б. Мөнхбат, З.Төмөртөмөө, Л.Ариунтуяа нар оролцлоо.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ХОЁР: Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлтэд удаашралтай байгаа арга хэмжээнүүдийг эрчимжүүлж, 2023 оны Нийслэлийн Хөгжлийн төлөвлөгөөнд тусгах саналаа тооцоо, судалгаагүй, хариуцлагагүй хандсан байгууллагуудын удирдлагуудад хариуцлага тооцож ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийт байгууллагууд/				
2.	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/90 дугаартай тушаалаар “Хөрөнгө оруулалтын төсвийн ажлуудын удаашралтай байгаа төсөл арга хэмжээг эрчимжүүлэх” ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэг нь 4 удаа хуралдаж, 3 удаа удаашралтай байгаа хөрөнгө оруулалтын ажлын явцтай танилцсан.</p> <p>2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар хөрөнгө оруулалтын ажлын үйл явцыг газар дээр нь очиж шалгасан.</p> <ul style="list-style-type: none"> ➤ 19 дүгээр хорооны “Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга”-н ажил - 70% ➤ 16 дугаар хорооны “Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга” - 100% ➤ 12 дугаар хорооны “Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга” - 80% ➤ 14 дүгээр хорооны “Гудамжны тохижилт, шинэчлэл” - 100%, ➤ 4 дүгээр хорооны “Сургуулийн 640 хүүхдийн барилгын өргөтгөл” - 90% <p>Дүүргийн эрүүл мэндийн төвийн амбулаторын барилгын өргөтгөлийг гүйцэтгэгч компани 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар 3 давхар хүртэлх цутгалт болон өрлөгийн ажил, 4 давхрын угсралтын ажил хийгдсэн.</p> <ul style="list-style-type: none"> ➤ 15 дугаар хорооны “Хорооплын доторх авто зам” - 90%-н гүйцэтгэлтэй байна. 	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар ГУРАВ: Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Дүүрэг, хорооны Засаг дарга нар, хэсгийн ахлагч болон агентлагийн дарга нартай уулзалттай, мөн цаашид иргэдтэй хийх уулзалтуудын бэлтгэл ажлыг сайтар хангах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дүүргийн Засаг дарга, Хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газар/				

3.	<p>Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн уулзалтад дүүргийн удирдлага 97,96%-н ирцтэйгээр 241 албан хаагчид оролцлоо.</p>		Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
	<p>Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/853 дугаар захирамжийн дагуу хэрэгжилтийг хангах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Инженерийн шугам сүлжээний ажлуудаа төлөвлөсөн график хугацаанд чанартай дуусгах. • 09 дүгээр сарын 15-с эхлэн айл өрх, сургууль, цэцэрлэгүүдийн халаалт өгөх. • Авто замын засвар, шинэчлэлийн ажлуудаа эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд багтаан чанартай гүйцэтгэж дуусгах. • Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн засвар шинэчлэлийн ажлуудыг эрчимжүүлж дуусгах. • Тохижилтын ажлуудаа эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд багтаан чанартай гүйцэтгэж дуусгах. • Нийтийн тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэл болон нийтийн тээврийн парк шинэчлэлийн ажлаа эрчимжүүлэх. • Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулж, автобусыг тогтмол цэвэрлэж, угаах түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. <p>/Захирагчийн ажлын алба Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд, Инженер хангамжийн байгууллагууд/</p>			
4.	<p>Дүүргийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажил 92%-н гүйцэтгэлтэй, ОСНААУГ ХҮТ 6, 7 төвүүдэд урсгал засварын ажил хийгдэж, 82%-н гүйцэтгэлтэй байна.</p> <p>ОСНААУГ ХҮТ 6, 7, халаалтын уур зуухны “Ану сервис” ХХК, “Элбэг дулаан” ХХК-иуд сургууль, цэцэрлэгт үзлэг шалгалт хийж, халаалтыг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн өгнө.</p> <p>Дүүргийн 13 дүгээр хороонд чулуун авто замын засвар, 9 дүгээр хороонд авто гүүрэн байгууламжийн засварын ажлыг Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК-р гүйцэтгүүлэн ажиллаж байна.</p> <p>Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн засвар шинэчлэлийн ажлуудыг эрчимжүүлж дуусгах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ 17 дугаар сургууль – Дээврийн хүрээ хөндийрсөн байсныг засварлаж, халаалтын системийг сольсон. “Үдийн хоол” хөтөлбөрийг гүйцэтгэхээр “Глобал вингс ХХК” компани тендерт шалгарч, үйл ажиллагаагаа явуулахаар урсгал засварын ажлаа эхлүүлсэн. ➢ 24 дүгээр сургууль – Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн гадна талбайн тохижилтын ажлын хүрээнд сагсны талбай байгуулсан. Мөн 80 метр урт цэвэр бохир усны шугам солих ажил бүрэн хийгдэж дууссан. ➢ 37 дугаар сургууль – “Үдийн хоол” хөтөлбөрийг гүйцэтгэхээр “Царим капитал ХХК” компани тендерт шалгарсан. ➢ 37, 50 дугаар сургууль - Дүүргийн Засаг даргын тамгын газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Япон улсын “Эрүүл хотыг дэмжигч төрийн бус байгууллага”-тай хамтран “Шүдний эрүүл мэндийг дэмжих төсөл” хэрэгжүүлэн “Евро деко” ХХК нь тус тус сургуулийн охид хөвгүүдийн ариун цэврийн өрөөг тохижуулан 22 угаалтуур суултуур суулгасан. ➢ 49 дүгээр сургууль – 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай “Цэвэр агаар тесөл”-н хүрээнд сургуулийн дээвэр, фасад дулаалга, цонх солих ажлууд бүрэн хийгдсэн. ➢ 61 дүгээр сургууль - Дотор сантехникийн 30 м шугам солих ажил бүрэн хийгдсэн. ➢ 117 дугаар сургууль- 1037 мкв фасадын ажил хийж гүйцэтгэсэн. ➢ 222 дугаар цэцэрлэг- Борооны ус зайлцуулах хоолойг засварласан. 	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70

	<ul style="list-style-type: none"> ➤ 154 дүгээр цэцэрлэг - "Цэвэр агаар төсөл"-н хүрээнд 321,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын хүрээнд сургуулийн дээвэр, фасадын дулаалга хийж, нийт 37ш цонх солигдсон. ➤ Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас сургууль цэцэрлэгийн цонхонд агаар шүүгч суулгах ажлын тендерт шалгарсан "Окфмл эко" ХХК нь 35 цэцэрлэг, 18 сургуульд нэг бүр нь 121.000 төгрөгийн үнэтэй нийт 556.963.000 төгрөгийн 4603 ширхэг агаар шүүгч суурилуулсан байна. <p>Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсан төсвийн тодотголын хүрээнд тохижилтын ажлуудын зураг төсвүүдийг боловсруулж, дүүргийн Худалдан авах ажиллагааны албанад 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр хүргүүлсэн бөгөөд хүйтний улирлаас өмнө дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Сайжруулсан шахмал тулшний нөөц 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар 8 агуулах 4 саравчинд 12892,5 тн байна. 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн борлуулалтын цэгүүдэд сайжруулсан шахмал тулшийг нийлүүлж эхэлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10 дугаар хорооны "Гудамж сайжруулах" төслийн ажил 90%-н гүйцэтгэлтэй явагдаж байна. ➤ Бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 17-ны Бямба гаригт дүүргийн хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. ➤ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хамтран ажиллах гэрээт "Улаанбаатар ариутгал" ХХК-р автобусны буудлын цэвэрлэгээ үйлчилгээ, хөөстэй угаалгыг 7 хоног бүр тогтмол хийж хэвшсэн. 		
Үүрэг, даалгавар TAB: Монгол Улсын Ерөнхий сайдын "2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай" 2022 оны 09 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг сайтар хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах. /Захирагчийн ажлын алба Хүнс, хөдөө аж ахуйн газар, Дүүргийн Засаг дарга нар/			
5.	<p>Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 03/232 дугаартай албан бичгийн дагуу дүүргийн иргэдийн ургац хураалтын урьдчилсан балансыг гаргасан. Дүүргийн хэмжээнд нийт 3,7 га-д төмс тариалснаас 27тн төмс, 9,1 га-д хүнсний ногоо тариалснаас 86тн хүнсний ногоо, 1,68 га-д жимс, жимсгэнэ тариалснаас 0,084тн жимс жимсгэнэ, ургац хураан статистик мэдээ гарсан. Мэдээллийг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Ашигт таримал, жимс, жимсгэнэй үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Н.Баярманлайд /egr.ulaaanbaatar.mn/ цахим хаягаар хүргүүлэн ажилласан.</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p> <p>70</p>
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрийн дагуу төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлж, төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, бүх шатанд төсөв, санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангаж, түүний хэрэгжилтэд Нийслэлийн Засаг Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсээс тогтмол хяналт тавьж ажиллах. /Нийт байгууллагуудын удирдлагуудад/			

6.	<p>Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, Дүүргийн Засаг даргын 2022 оны "Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах" тухай А/45 дугаар захирамжийг 2022 оны 4/246 тоот албан бичгээр, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг даргын 2022 оны 1/1745 тоот албан бичгээр харьяа 69 байгууллагын төсвийн шууд захирагч наарт хүргүүлж, өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан.</p> <p>Үүрэг, даалгавар Долоо: Орлого төвлөрүүлэгч байгууллагууд орлогын тасалдлыг нөхөж, төсвийн орлогын гүйцэтгэлийг хангах ажлаа эрчимжүүлж ажиллах. /Нийт байгууллагуудын удирдлагуудад/</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
7.	<p>Дүүргийн Татварын хэлтсийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 2022 оны 9 дүгээр сарын 12-ны байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Дүүргийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 15,558.4 сая, гүйцэтгэл 1,841.4 сая, гүйцэтгэлийн хувь 11.8%, ессен дунгээр гүйцэтгэлийн хувь 86.84%-тай байна. ➢ Дүүргийн 6-19 дүгээр хороодын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийг тоолох ажлыг 9 сард зохион байгуулж гарсан эхний үр дунгээр 320 гаруй татвар төлөгч ААН, иргэдийг хамруулан бүртгэлжүүлэх ажлыг хийж байна. ➢ Нийт 1864 татвар төлөгчийн 6.2 тэрбум төгрөгийн өрийн дунд нэхэмжлэх хүргүүлэх, 11 Банк, ББСБ-н 1.7 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдлийг төлүүлэх тооцооллыг тулгах, татвар торгуулийн 5.0 орчим тэрбум төгрөгийг төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр байцаагч бүрд өдөрт 10-20 татвар төлөгчийн өр, төлбөрийг барагдуулах чиглэл өгч татварт хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
8.	<p>Үүрэг, даалгавар НАЙМ: Нутгийн захиргааны байгууллагуудын хариуцсан салбар чиглэлийн хүрээнд гаргасан бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж ажиллах. /Нийт байгууллагуудын удирдлагуудад/</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 3/1825 тоот албан бичгээр Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах талаар Тамгын газрын хэлтэс албадад чиглэл хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын А/01, A/59, A/212, A/397, A/474, A/448, A/655, A/798 дугаар нийт 8 захирамжийн биелэлт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01/01, 01/03, 02/04, 08/01 дүгээр нийт 4 хуралдааны тэмдэглэлийн биелэлтийг дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албадаас улирал бүр нэгтгэн авч Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын А, Б захирамж, Тамгын газрын даргын А, Б тушаалын хэрэгжилтийн тайланг 9 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар хэлтэс, албадаас гаргуулан авч, уг тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийхээр бэлтгэл ажил хангаждаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
9.	<p>Үүрэг, даалгавар ЕС : Нийслэлийн Бодлогын судалгаа, шинжилгээний төвийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа, тоо баримт, танилцуулгыг шуурхай гарган өгч, бодлого, төлевлөлтийн хүрээнд хамтран ажиллах. /Нийт байгууллагуудын удирдлагуудад/</p>			50

	шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн Т.Итгэл /erg/ хаягаар 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр хүргүүлэн ажилласан.		
Үүрэг, даалгавар АРАВ: Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтаанд гаргасан өргөдөл, гомдол, албан бичгийг бүх талаас нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх, хариуцлагагүй хандсан албан хаагч, удирдлагад хариуцлага тооцож ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Хэрэгжүүлэгч агентлаг, Дүүргийн Засаг дарга нар/			
10.	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтэд хяналт, шалгалт хийсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 3/2188 тоот албан бичгээр өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд анхаарч ажиллах зөвлөмжийг Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад хүргүүлэн ажилласан.</p> <p>Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, хороо, сургууль, цэцэрлэгүүдэд ирсэн албан бичгийн нэгдсэн тайлангаар удаа дараа хугацаа хэтрүүлэн, зөрчил тооцогдсон нийт 10 байгууллагад холбогдох арга хэмжээ авхуулах санал, дүгнэлтийг Нийслэлийн архивын газарт 3/1730 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу НАГ-ын Улсын байцаагчийн албан шаардлага ирүүлснийг холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.</p> <p>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллагуудад 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар нэгдсэн систем дэх:</p> <ul style="list-style-type: none"> • Албан бичгийн шийдвэрлэлт, • Системийн ашиглалт, • Хүний нөөцийн бүртгэл, • Стандартын хяналтыг тус тус тавин хянан ажиллаж байна. 		70

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ


ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДХУРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА


П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.ХАНГАЙ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА  М.НАВЧАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Ж.ДУЛМАА

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Т.ТУВШИНЖАРГАЛ